



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/150

Өмнөдэлгэр сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2026 оны 05/5637 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогүй тул Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Б.Гантулгад Санхүүгийн албаны даргын үүрэгт ажлыг санхүүгийн албаны дарга томилогдох хүртэл хугацаанд түр хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Санхүүгийн албаны даргын үүрэгт ажлыг хариуцлагатай гүйцэтгэж, санхүүгийн алба болон төрийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг хугацаанд нь гаргуулж, идэвх санаачилгатай ажиллахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.



РЭНХТӨР

2326310300

D:\disk\bichig hereg/ zahiramj/